



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/546

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", 29.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн нутаг дэвсгэрт байгалийн гамшигт үзэгдэл болж нутгийн иргэд зуслангийн бүсэд хаагдсантай холбогдуулан тус багийн Улиастай голын Цагаан гатлагаар гүүр хоолойн гарц гаргах зардалд зориулж 8 440 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 8 440 000 /найман сая дөрвөн зуун дөчин мянга/-н төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.18 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны А/446 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ